



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2026 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 183

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө шилжүүлэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 3 нэрийн, нийт 633,960,000.00 төгрөг (зургаан зуун гучин гурван сая есөн зуун жаран мянга)-ийн балансын үнэ, 45,327,469.22 төгрөг (дөчин таван сая гурван зуун хорин долоон мянга дөрвөн зуун жаран есөн төгрөг хорин хоёр мөнгө)-ийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг төрийн өмчит үйлдвэрийн газарт хавсралтад заасны дагуу шилжүүлсүгэй.

2. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Оргил, “Эрдэнэс критикал минералс” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Мөнхсайхан, “Засгийн газрын авто бааз” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Г.Чинзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим системд бүртгэх;

2.3. Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2026 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132901016

2026/11-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2026 оны 2 дугаар сарын 14-ны өдрийн
183 дугаар тогтоолын хавсралт

"ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэр лэсэн/ ашиглал - тад орсон огноо	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шилжүүлэн авах байгууллага
1	Тоёота Гранвиа, 08- 85УБЭ, JTFYM3APX08001654	2024/2024	127,160,000.00	36,911,805.48	90,248,194.52	"Эрдэнэс критикал минералс" төрийн өмчит үйлдвэрийн газар
2	Хьюндай Соната, 09- 43УБЛ, KMHL341ABTA529467	2025/2025	127,000,000.00	8,415,663.74	118,584,336.26	
3	Ниссан Патрол Y63LE, 67- 80УНЕ, JN1Y63TA8Z0010833	2026/2026	379,800,000.00	-	379,800,000.00	"Засгийн газрын авто бааз" төрийн өмчит үйлдвэрийн газар
	НИЙТ ДҮН		633,960,000.00 (зургаан зуун гучин гурван сая есөн зуун жаран мянга)	45,327,469.22 (дөчин таван сая гурван зуун хорин долоон мянга дөрвөн зуун жаран есөн төгрөг хорин хоёр мөнгө)	588,632,530.78 (таван зуун наян найман сая зургаан зуун гучин хоёр мянга таван зуун гучин төгрөг далан найман мөнгө)	